



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АЙМАГ ДУНДЫН ОТРЫН БЭЛЧЭЭР АШИГЛАЛТЫН ЗАХИРГААНЫ  
2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН  
АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/195/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх  
аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер С.Нацагдорж  
Утас: 261628 Цахим хаяг: [natsagdorjs@audit.gov.mn](mailto:natsagdorjs@audit.gov.mn)  
Аудитор Л.Мөнхцацрал  
Утас: 261740 Цахим хаяг: [munkhtsatsrall@audit.gov.mn](mailto:munkhtsatsrall@audit.gov.mn)  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Дундманхайдай аудит” ХХК  
Захирал Ж.Бямбажав  
Утас: 11-325262 Цахим хаяг: [dum\\_audit@yahoo.com](mailto:dum_audit@yahoo.com)

Улаанбаатар хот  
2022 он

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	13
3. Аудитын тайлан .....	14
3.1 Ерөнхий зүйл .....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	15
3.4 Материаллаг байдал .....	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	17
3.8 Аудитын гол асуудал .....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	19
4. Аудитын илрүүлэлт .....	19
4.1 Залруулсан алдаа .....	19
4.2 Төлбөрийн акт .....	19
4.3 Албан шаардлага .....	20
4.4 Зөвлөмж .....	20
5. Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл .....	21

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГ	Засгийн газар
НА	Нотлох баримт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

᠒᠐᠒᠒.᠐᠗.25 № ᠐ᠭ/413  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

АЙМАГ ДУНДЫН ОТРЫН БЭЛЧЭЭР  
АШИГЛАЛТЫН ЗАХИРГААНЫ ДАРГА  
Д.ТҮМЭНДЭМБЭРЭЛ ТАНАА

### Аудитын санал дүгнэлт

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>125,536,501.00</b>	<b>109,033,809.44</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>100,222,141.00</b>	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	100,222,141.00	-
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	-	<b>10,800,000.00</b>
34600	Урьдчилж гарсан зардал	-	10,800,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	25,314,360.00	98,233,809.44
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	25,314,360.00	98,233,809.44
35410	Бичиг хэргийн материал	8,149,780.00	8,410,780.00
35420	Аж ахуйн материал	1,474,000.00	2,249,369.00
35430	Сэлбэг хэрэгсэл	6,837,000.00	7,102,000.00
35440	Түлш, шатах тослох материал	-	1,589,038.44
35470	Бусад хангамжийн материал	8,853,580.00	78,882,622.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,769,469,946.13</b>	<b>4,269,752,911.23</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>2,769,469,946.13</b>	<b>4,269,752,911.23</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,760,479,594.53</b>	<b>3,216,782,559.59</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,947,446,765.27	1,947,446,765.27
39202	Хуримтлагдсан элэгдэл	(798,607,916.74)	(892,432,871.50)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	370,611,920.77	364,861,920.77
39204	Хуримтлагдсан элэгдэл	(267,580,255.17)	(290,656,922.17)
39205	Машин тоног төхөөрөмж	435,958,057.00	2,125,769,150.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(350,822,676.68)	(355,031,690.73)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	32,497,274.96	28,813,329.84
39208	Хуримтлагдсан элэгдэл	(20,599,135.25)	(18,399,477.10)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,301,019,528.00	1,248,528,828.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(889,443,967.63)	(942,116,472.79)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>1,008,990,351.60</b>	<b>1,052,970,351.64</b>
39301	Программ хангамж	3,540,170.00	48,040,170.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,240,170.00)	(1,760,169.96)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,006,690,351.60	1,006,690,351.60
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,895,006,447.13</b>	<b>4,378,786,720.67</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,895,006,447.13</b>	<b>4,378,786,720.67</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>2,895,006,447.13</b>	<b>4,378,786,720.67</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/	2,532,738,464.28	2,532,738,464.28
51101	Өмч: - төрийн	2,532,738,464.28	2,532,738,464.28
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>252,954,285.38</b>	<b>1,736,734,558.92</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	506,839,770.79	252,954,285.38
51220	Тайлант үеийн үр дүн	(253,885,485.41)	1,483,780,273.54
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	109,313,697.47	109,313,697.47
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,895,006,447.13</b>	<b>4,378,786,720.67</b>



## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>853,973,227.00</b>	<b>2,389,693,190.60</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>7,417,727.00</b>	<b>1,862,915,148.60</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	7,417,727.00	1,862,915,148.60
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,417,727.00	1,862,915,148.60
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,417,727.00	1,862,915,148.60
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>846,555,500.00</b>	<b>526,778,042.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	516,209,300.00	498,620,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	516,209,300.00	498,620,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	330,346,200.00	28,158,042.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	316,000,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс	14,246,200.00	28,158,042.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	100,000.00	-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,107,858,712.41</b>	<b>887,158,117.06</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,107,858,712.41</b>	<b>887,158,117.06</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,106,298,092.84	874,765,105.70
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	239,376,443.39	283,971,262.10
210101	Үндсэн цалин	179,886,522.15	188,322,595.28
210102	Нэмэгдэл	50,144,921.24	75,822,001.63
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,345,000.00	19,826,665.19
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	29,525,226.11	36,181,546.45
210201	Тэтгэврийн даатгал	20,334,892.32	25,195,215.60
210202	Тэтгэмжийн даатгал	2,392,340.27	2,840,438.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,913,872.46	2,272,350.62
210204	Ажилгүйдлийн даатгал	141,510.84	525,643.54
210205	Эрүүл мэндийн даатгал	4,742,610.22	5,347,898.23
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	1,893,400.00	-
210304	Байрны түрээс	1,893,400.00	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	82,959,546.00	19,378,563.65
210401	Бичиг хэрэг	16,153,100.00	1,458,100.00
210402	Тээвэр, шатахуун	57,380,096.00	13,578,492.56
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,470,800.00	1,681,471.09
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,955,550.00	2,660,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	-	250,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	250,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	37,389,802.00	32,903,007.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	857,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	309,000.00
210604	Урсгал засвар	37,389,802.00	31,736,407.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	5,632,180.00	9,580,200.00
210702	Дотоод албан томилолт	5,632,180.00	9,580,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	321,404,541.93	185,454,919.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	314,520,107.93	167,735,985.60
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,500,000.00	15,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	360,000.00	899,120.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,197,137.00	1,123,638.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	82,000.00	154,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000.00	-
210807	Газрын төлбөр	345,297.00	542,176.00

Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	388,116,953.41	307,045,606.90
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	75,554,577.00	6,547,472.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	312,562,376.41	300,498,134.90
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,560,619.57	12,393,011.36
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,045,500.00	6,075,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,045,500.00	6,075,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	515,119.57	6,318,011.36
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	515,119.57	6,318,011.36
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b>	<b>253,885,485.41)</b>	<b>1,502,535,073.54</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	18,754,800.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	18,754,800.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	(18,754,800.00)
<b>5</b>	<b>НИИТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(253,885,485.41)</b>	<b>1,483,780,273.54</b>



### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>889,944,850.00</b>	<b>627,000,183.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>889,944,850.00</b>	<b>627,000,183.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	516,209,300.00	498,620,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	516,209,300.00	498,620,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>373,735,550.00</b>	<b>128,380,183.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	359,389,350.00	100,222,141.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,246,200.00	28,158,042.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	100,000.00	-
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>880,034,850.00</b>	<b>617,719,083.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>880,034,850.00</b>	<b>617,719,083.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>777,752,089.43</b>	<b>605,326,071.64</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	181,500,600.00	283,971,262.10
210101	Үндсэн цалин	114,684,083.31	188,322,595.28
210102	Нэмэгдэл	57,472,916.69	75,822,001.63
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,343,600.00	19,826,665.19
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	24,502,500.00	36,181,546.45
210201	Тэтгэврийн даатгал	17,242,500.00	25,195,215.60
210202	Тэтгэмжийн даатгал	1,815,000.00	2,840,438.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,452,000.00	2,272,350.62
210204	Ажилгүйдлийн даатгал	363,000.00	525,643.54
210205	Эрүүл мэндийн даатгал	3,630,000.00	5,347,898.23
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	1,893,400.00	-
210304	Байрны түрээс	1,893,400.00	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	19,581,950.00	22,177,760.09
210401	Бичиг хэрэг	2,428,900.00	2,098,600.00
210402	Тээвэр, шатахуун	13,154,500.00	15,720,320.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,470,800.00	1,681,471.09
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	527,750.00	2,677,369.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	521,000.00	2,187,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	521,000.00	2,187,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	57,112,502.00	45,768,767.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	114,300.00	19,612,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	301,500.00
210604	Урсгал засвар	56,998,202.00	25,854,867.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	6,170,080.00	9,564,990.00
210702	Дотоод албан томилолт	6,170,080.00	9,564,990.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	478,006,557.43	198,932,774.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	474,522,123.43	170,413,840.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	15,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	360,000.00	899,120.00

Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,197,137.00	1,123,638.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	82,000.00	154,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,500,000.00	10,800,000.00
210807	Газрын төлбөр	345,297.00	542,176.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>8,463,500.00</b>	<b>6,541,972.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,463,500.00	6,541,972.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>102,282,760.57</b>	<b>12,393,011.36</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,545,500.00</b>	<b>6,075,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,545,500.00	6,075,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>100,737,260.57</b>	<b>6,318,011.36</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	100,737,260.57	6,318,011.36
<b>3</b>	<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ (3)=(1)-(2)</b>	<b>9,910,000.00</b>	<b>9,281,100.00</b>
<b>5</b>	<b>Хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дүн (5)</b>	<b>9,910,000.00</b>	<b>9,281,100.00</b>
<b>22</b>	<b>Хөрөнгийн зардал</b>	<b>9,910,000.00</b>	<b>9,281,100.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>9,910,000.00</b>	<b>9,281,100.00</b>
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	9,910,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	9,281,100.00
<b>6</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ (6)=(4)-(5)</b>	<b>(9,910,000.00)</b>	<b>(9,281,100.00)</b>
<b>8</b>	<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан  
/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	1,526,048,112.68	109,313,697.47	506,839,770.79	3,148,891,932.54
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,526,048,112.68</b>	<b>109,313,697.47</b>	<b>506,839,770.79</b>	<b>3,148,891,932.54</b>
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(253,885,485.41)	(253,885,485.41)
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,526,048,112.68</b>	<b>109,313,697.47</b>	<b>252,954,285.38</b>	<b>2,895,006,447.13</b>
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	2,532,738,464.28	109,313,697.47	252,954,285.38	2,895,006,447.13
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,483,780,273.54	1,483,780,273.54
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,532,738,464.28</b>	<b>109,313,697.47</b>	<b>1,736,734,558.92</b>	<b>4,378,786,720.67</b>

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2021 оны 12 дугаар 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	498,625,100.00	492,301,988.64	(6,323,111.36)	98.7
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	498,625,100.00	492,301,988.64	(6,323,111.36)	98.7
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	492,288,700.00	486,226,988.64	(6,061,711.36)	98.7
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	285,152,200.00	283,971,262.10	(1,180,937.90)	99.5
210101	Үндсэн цалин	188,592,600.00	188,322,595.28	(270,004.72)	99.8
210102	Нэмэгдэл	76,016,000.00	75,822,001.63	(193,998.37)	99.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,543,600.00	19,826,665.19	(716,934.81)	96.5
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	39,615,600.00	36,181,546.45	(3,434,053.55)	91.3
210201	Тэтгэврийн даатгал	27,878,400.00	25,195,215.60	(2,683,184.40)	90.3
210202	Тэтгэмжийн даатгал	2,934,000.00	2,840,438.46	(93,561.54)	96.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,347,200.00	2,272,350.62	(74,849.38)	96.8
210204	Ажилгүйдлийн даатгал	586,800.00	525,643.54	(61,156.46)	89.5
210205	Эрүүл мэндийн даатгал	5,869,200.00	5,347,898.23	(521,301.77)	91.1
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	15,594,300.00	15,577,760.09	(16,539.91)	99.8
210401	Бичиг хэрэг	2,098,700.00	2,098,600.00	(100.00)	100.0
210402	Тээвэр, шатахуун	9,136,000.00	9,120,320.00	(15,680.00)	99.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,682,200.00	1,681,471.09	(728.91)	99.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,677,400.00	2,677,369.00	(31.00)	100.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	2,187,000.00	2,187,000.00	-	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,187,000.00	2,187,000.00	-	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	30,146,400.00	30,043,467.00	(102,933.00)	99.6
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,960,000.00	3,887,100.00	(72,900.00)	98.1
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	305,000.00	301,500.00	(3,500.00)	98.8
210604	Урсгал засвар	25,881,400.00	25,854,867.00	(26,533.00)	99.9
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	9,570,700.00	9,564,990.00	(5,710.00)	99.9
210702	Дотоод албан томилолт	9,570,700.00	9,564,990.00	(5,710.00)	99.9
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	103,480,000.00	102,158,991.00	(1,321,009.00)	98.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	88,649,000.00	88,640,057.00	(8,943.00)	99.9
210803	Даатгалын үйлчилгээ	903,700.00	899,120.00	(4,580.00)	99.4
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,606,300.00	1,123,638.00	(482,662.00)	69.9
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	577,000.00	154,000.00	(423,000.00)	26.6
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,800,000.00	10,800,000.00	-	100.0
210807	Газрын төлбөр	944,000.00	542,176.00	(401,824.00)	57.4
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	6,542,500.00	6,541,972.00	(528.00)	99.9
210901	Бараа үйлчилгээний	6,542,500.00	6,541,972.00	(528.00)	

Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	бусад зардал				99.9
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	6,336,400.00	6,075,000.00	(261,400.00)	95.8
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	6,336,400.00	6,075,000.00	(261,400.00)	95.8
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,336,400.00	6,075,000.00	(261,400.00)	95.8
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>498,625,100.00</b>	<b>492,301,988.64</b>	<b>(6,323,111.36)</b>	<b>98.7</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>498,625,100.00</b>	<b>492,301,988.64</b>	<b>(6,323,111.36)</b>	<b>98.7</b>
122005	Орон нутгийн төсвөөс	498,625,100.00	492,301,988.64	(6,323,111.36)	98.7
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>				
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>		
610001	Төсвийн байгууллага	1	1		
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>24</b>	<b>24</b>		
620001	Удирдах ажилтан	1	1		
620002	Гүйцэтгэх ажилтан	15	15		
620004	Гэрээт ажилтан	8	8		

**2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

2021 оны 12 дугаар 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>128,380,183.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>128,380,183.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>128,380,183.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		<b>6,600,000.00</b>
210401	Бичиг хэрэг		
210402	Тээвэр, шатахуун		6,600,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		<b>25,006,400.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл		25,006,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		<b>96,773,783.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		81,773,783.00
210802	Аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		15,000,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>128,380,183.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>128,380,183.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		100,222,141.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		28,158,042.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад цалин хөлсний тооцоо, татвар, нийгмийн даатгалын тайланг үнэн зөв тайлагнах, үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалт, бараа материалын худалдан авах, ажил үйлчилгээний төлбөрийг И баримтаар баталгаажуулж ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 25-аас 2022 оны 2 дугаар сарын 25-ны хооронд Дундманхайдай Аудит ХХК-ийн ахлах аудитор С.Батжаргал, Н.Тэмүүжин нар гүйцэтгэж, захирал Ж.Бямбажав хянан удирдаж, чанарын хяналтыг аудитын менежер Б.Цэвэлмаа хэрэгжүүлсэн.

Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 27 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа нь “Аймаг дундын отрын бүсийн бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах замаар мал сүргийг байгалийн гэнэтийн болон давагдашгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, оторчид, малчдад, төрийн үйлчилгээг үзүүлэх” чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- ЗГ-ын 118 дугаар тогтоол “Төрийн байгууллагын үйл ажиллагааны түр горим тогтоох тухай” зэрэг тогтоол.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа нь Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 01/2589 тоот албан бичиг, хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын дотоод хяналт шинжилгээний дүгнэлт, зөвлөмжийн дагуу үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлэн ажиллаж байна.



Тайлант онд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас 2021 оны 8 дугаар сард хяналт шалгалт хийж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 1/3166 дугаартай “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дүгнэлт, зөвлөмжийг ирүүлсэн, зөвлөмжийн биелэлтийг гаргаж хүргүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг төсвийн тухай хуулийн 54.5-д заасан бүрэлдэхүүн хэсгийн дагуу иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 498,625.7 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 7,479.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,483,780.3 мянган төгрөгөөр буюу 51.3 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь авлага, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгө дансдууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3
Авлага	100,222.1	0.0	(100,222.1)
Урьдчилгаа	0.0	10,800.0	10,800.00
Бараа материал	25,314.3	98,233.8	72,919.5
Үндсэн хөрөнгө	2,769,469.9	4,269,752.9	1,500,283.0
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>2,895,006.4</b>	<b>4,378,786.7</b>	<b>1,483,780.3</b>
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,532,738.5	2,532,738.5	-
Хуримтлагдсан ашиг	252,954.3	1,736,734.6	1,483,780.3
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	109,313.7	109,313.7	-
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>2,895,006.4</b>	<b>4,378,786.7</b>	<b>1,483,780.3</b>

Авлагын дансны үлдэгдэл 100,222.1 мянган төгрөгөөр буурсан нь Швейцарын хөгжлийн агентлаг “Ногоон алт малын эрүүл мэнд” төслөөс татаас санхүүжилтийн авлагыг авч, зориулалтын дагуу зарцуулагдсан байна.

Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл 10,800.0 мянган төгрөгөөр өссөн нь программ хангамжийн үйлчилгээ нийлүүлэх гэрээний дагуу Төсвийн хяналтын нэгдсэн онлайн платформын 2022 оны үйлчилгээний төлбөр урьдчилж төлснөөс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 98,233.8 мянган төгрөгөөр өссөн нь өвс тэжээлийн нөөц бий болгож, мал сүргийн байгалийн эрсдэлийг даван туулах чадамжийг нэмэгдүүлэх, байгалийн гэнэтийн болон давагдашгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Чойбалсан сумын Засаг даргын тамгын газраас 3,500 боодол ногоон тэжээл, 9,100 боодол өвсийг зах зээлийн ханшаар нэг бүрийг 5.0 мянган төгрөгөөр үнэлэн нийт 63,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд хандив тусламжаар бүртгэн орлого авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,269,752.9 мянган төгрөг болж, 1,500,283.0 мянган төгрөгөөр өссөн нь Швейцарын хөгжлийн агентлагийн Ногоон алт, малын эрүүл мэнд төслийн 2017-2021 оны хооронд хэрэгжүүлсэн төслийн ажлын хүрээнд 44,500.0 мянган төгрөгийн өртгөөр бий болсон “Отрын бүс нутгийн бэлчээр ашиглалтын мэдээллийн цахим сан” программ хангамж, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн А/392 дугаар албан бичгээр салбарын хөрөнгө оруулалтаас шилжиж ирсэн 46 ширхэг 1,747,000.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгийн дансанд хандив тусламжаар бүртгэн орлого авсантай холбоотой байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 28 дугаар тогтоолоор 5,750.0 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 44,184.5 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 52,490.7 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, 2021 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн А1/125 дугаар тушаалаар 25,969.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хассан байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 578,111.9 мянга, нийт зарлагыг 578,111.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 79,486.8 мянган төгрөгөөр дутуу 498,625.1 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 498,625.1 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 498,620.0 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч, урсгал үйл ажиллагаанд 492,302.0 мянган төгрөгийг зарцуулж, 6,318.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 492,302.0 мянган төгрөг буюу 98.7 хувьтай байгаа нь Цалин хөлс болон нэмэгдэл урамшил 1,180.9 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл НДШ 3,434.1 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,

хураамж зардлыг 1,321.0 мянган төгрөг, нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг 261.4 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

*/мянган төгрөг/*

д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	70801	Мал аж ахуйг хөгжүүлэх	498,625.1	492,302.0	6,323.1	98.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Швейцарын хөгжлийн агентлагийн “Ногоон алт, малын эрүүл мэнд” төсөл хөтөлбөрийн санхүүжилт 100,222.1 мянга, мал амьтны сэг зэм устгах арга хэмжээнд Мал эмнэлгийн ерөнхий газраас 28,158.1 мянган төгрөгийн, нийт 128,380.2 мянган төгрөгийн санхүүжилт бүрдүүлсэн байна.

Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 96,773.8 мянга, хангамж, бараа материалын зардалд 6,600.0 мянга, эд хогшил, урсгал засварын зардалд 25,006.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилтын хүрээнд 23 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 98.7 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн А/110 тоот тушаалаар орон тоо, үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг, 2021 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн А/275 тоот тушаалаар байгууллагын дүрмийг, 2021 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн А/276 тоот тушаалаар байгууллагын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөг тус тус шинэчлэн батлуулж санхүү, аж ахуйн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 5 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант онд нийт 589,556.2 мянган төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 141 мэдээллийг бүрэн байршуулж, 57,143.1 мянган төгрөгийн 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 *”тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”*, 6 дугаар зүйлийн 6.1-т *”Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”* гэж заасантай тус тус нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж хүргүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа нь 2020 оны А/66 дугаар тушаалаар өмч хамгаалах байнгын зөвлөлийг 4 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан шууд болон харьцуулалтын аргаар үндсэн үйл ажиллагаанд 106,711.1 мянган төгрөгийн худалдан авалтыг 100 хувь зохион байгуулж, гүйцэтгэлийг тайлагнасан байна.

Завсрын аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хүрээнд холбогдох байгууллагуудад дараах асуудлуудыг шийдвэрлэхээр албан бичгийг хүргүүлсэн боловч тайлант хугацаанд шийдвэрлэгдээгүй байна. Улсын бүртгэлийн гэрчилгээнд дүрмийн сангийн хөрөнгийн дүн 2,531,037.6 мянган төгрөгийг нэмэлт өөрчлөлтийг хийгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д *”нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцээгүй байх”* гэж заасныг хэрэгжүүлээгүй, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Улсын бүртгэлийн гэрчилгээнд дүрмийн сангийн өөрчлөлтийг хийлгэх зөвлөмж өгсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн худалдан авалт нь хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

### **3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 736.0 мянган төгрөгийн 1 актыг барагдуулан, 2,495.9 мянган төгрөгийн зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангасан байна. Аудитаар өгсөн нийт 3,967.9 мянган төгрөгийн 4 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	736.0	1	736.0	-	-	100
Зөвлөмж	4	2,459.9	4	2,459.9	-	-	100
Нийт дүн	5	3,967.9	5	3,967.9	-	-	100

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Бараа материал дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгө бүртгэсэн болон үндсэн хөрөнгийн үлдэх өртөггүй хөрөнгүүдийг шийдвэрлэсэн байдлыг авч үзнэ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,098,455.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1,093,283.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,826.4 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 3,345.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 5,172.2 мянган төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшиний 7,479.4 мянган төгрөгөөс бага байгаа тул Зөрчилгүй санал дүгнэлт өглөө.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Тайлант хугацаанд нийт 4,203.1 мянган төгрөгийн бараа материалыг мөнгөн хөрөнгөөс тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардалд бүртгэсэн;
- Бараа материалын 68,013.9 мянган төгрөгийн худалдан авалтыг и баримтаар баталгаажуулаагүй байсныг нөхөж шивүүлсэн;
- Тайлант хугацаанд 3,575.7 мянган төгрөгийн сургалтын хүнсний материалыг өглөгийн данснаас шууд зардалд бүртгэсэн
- Санхүүгийн байдлын тайлангийн эздийн өмчийн бусад хэсэг дансны эхний үлдэгдэл өмнөх оны аудитлагдсан тайлангаас 1,006,690.3 мянган төгрөгөөр дутуу илэрхийлэн тайлагнасан;
- “Даталанд технологи” ХХК-тай байгуулсан "Программ хангамжийн үйлчилгээний гэрээ"-ний дагуу Төсвийн хяналтын нэгдсэн онлайн платформын үнэ 10,800.0 мянган төгрөгийн төлбөр шилжүүлснийг биет бус хөрөнгөөр бүртгэсэн.

### 4.2 Төлбөрийн акт

Хөлсөөр ажиллах гэрээгээр 2 иргэнд нийт 7,610.0 мянган төгрөгийн цалин олгохдоо 1,826.4 мянган төгрөгийн НДШ-ийг суутгаагүй нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-д "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2014 онд баталсан “Эдийн засгийн ангилал батлах тухай” 5 дугаар тушаалын “Цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардлын ангилалд ажиллагсдын цалин, хөлс болон хуулиар нийгмийн даатгалын шимтгэл бодогдох нэмэгдэл урамшлын зардлууд хамаарна” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

### **4.3. Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Татвар, нийгмийн даатгалын тайлантай холбоотой асуудал**

##### **1.1. Илрүүлэлт:**

Цалингийн тооцооны хүснэгтээр олгосон цалингийн дүнг татварын тайлан, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлантай тулган шалгахад 5 ажилтны 3,345.8 мянган төгрөгийг цалинг НДШ төлөлтийн тайланд дутуу тайлагнасан байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулий 17 дугаар зүйлийн 17.1.1-д "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэсэнтэй нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### **1.2. Өгсөн зөвлөмж:**

Ажиллагсадын цалин хөлсийг үнэн зөв тооцож, татвар, нийгмийн даатгалын тайланг холбогдох хууль тогтоомжийн дагуу тайлагнаж байх.

#### **2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

##### **2.1. Илрүүлэлт:**

Үндсэн хөрөнгийн дансанд ашиглаж байгаа боловч элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй 704,338.0 мянган төгрөгийн 40 нэр төрлийн хөрөнгийг холбогдох байгууллагад хүсэлт гаргаж шийдвэрлүүлээгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-т "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох" гэж заасантай нийцэхгүй, үнэлгээ ба хувиарлалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### **2.2. Өгсөн зөвлөмж:**

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийг холбогдох байгууллагад хүсэлт гаргаж шийдвэрлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.





		2022/348/Н А-СТА-ТШЗ	программын үнэ 10,800.0 мянган төгрөгийг УГЗ дансанд үлдэгдлээр залруулан бүртгэлд тусгасан боловч төсвөөс урьдчилан мөнгийг шилжүүлсэн байна.	Залруулга	1	10,800.0	1	10,800.0						
5	АДОБАЗ	АХГ- 2022/348/Н А-СТА-ТШЗ	Тайлант хугацааны авлага, өглөгийн дансны үлдэгдлийн шийдвэрлэлт, тайлангийн үлдэгдэл зөрүүтэй, ББХ, бараа материал данс бүртгэлд тусгаагүй зэрэг зөрчлийг залруулсан.	Залруулсан	4	1,082,483.1	4	1,082,483.1						
<b>ДҮН</b>					<b>8</b>	<b>1,098,455.3</b>	<b>5</b>	<b>1,093,283.1</b>	<b>1</b>	<b>1,826.4</b>			<b>2</b>	<b>3,345.8</b>
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал														
1	АДОБАЗ	АХГ- 2022/348/Н А-СТА-ТШЗ	Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 57,143.1 мянган төгрөгийн 17 ажил, гүйлгээг шилэн дансны цахим системд хугацаа хоцроож байршуулсан байна.	Зөвлөмж	1								1	-
2	АДОБАЗ	АХГ- 2022/348/Н А-СТА-ТШЗ	Улсын бүртгэлийн гэрчилгээ дэх дүрмийн сангийн хөрөнгийн дүнгээс санхүүгийн тайлангийн төрийн өмчийн дүн 2,531,037.6 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.	Зөвлөмж	1								1	-
<b>ДҮН</b>					<b>2</b>								<b>2</b>	
<b>НИЙТ ДҮН</b>					<b>10</b>	<b>1,098,455.3</b>	<b>5</b>	<b>1,093,283.1</b>	<b>1</b>	<b>1,826.4</b>			<b>4</b>	<b>3,345.8</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2022 оны 02 дугаар сарын 25

№ 39/А0150458

Улаанбаатар хот

АХТ - 2022/348/НА-СН-ТМЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөлсөөр ажиллах гэрээгээр ажилласан 2 иргэнд нийт 7,610,000.00 төгрөгийн цалин олгоходоо 1,826,400.00 төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг суутгаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7 "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 41 дүгээр зүйлийн 41.2.3 "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 "Дараах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод нийгмийн даатгалын шимтгэл ногдуулна: Хөдөлмөрийн тухай хуулийн 83.5 дахь хэсэг, 101 дүгээр зүйлд заасан цалин хөлс, 113, 114, 115, 116, 117 дугаар зүйлд заасан олговор" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хөлсөөр ажиллах гэрээгээр ажилласан 2 иргэний цалин хөлснөөс суутган тооцоогүй 1,826,400.00 /нэг сая найман зуун хорин зургаан мянга дөрвөн зуу/ төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг харьяа Нийгмийн даатгалын байгууллагын холбогдох дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны дарга Д.Түмэндэмбэрэл, Нягтлан бодогч Т.Даваажаргал нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

АУДИТЫН ХОЁР ДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
С.НАЦАГДОРЖ  
Ж.БЯМБАЖАВ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй оүүрэг, 1-р хороо, Бага тойруу 3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264280

9019120396

W:\0\_10\11.20\Bichig\_Khereg\Akt\2022\0225 Auditin 4 Газар-43.Docx

0001090148

